



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/352

Хэрлэн сум

Нэг жуулчин–Нэг унага эвент
арга хэмжээний маркетинг сурталчилгаа хийхэд
хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1, 23.1.9, 23.1.11 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны Аймгийн 2024 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ, эвент арга хэмжээг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлэх, аймаг орон нутгаа сурталчлах, нүүдэлчин ахуй соёл, адуу маллах зан заншил, уламжлалыг сэргээх, олон улсын хэмжээнд сурталчлан таниулах зорилгоор Нэг жуулчин-Нэг унага эвент арга хэмжээг олон нийтэд танилцуулах маркетинг сурталчилгаа хийхэд 9,000,000 (есөн сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга) -д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
...дугаар сарын...-ны өдрийн
...дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зохион байгуулагдах арга хэмжээ	Тоо хэмжээ	Төсөв ₮
1	Нэг жуулчин –Нэг унага эвентийн лого зохион бүтээх	1	1,000,000
2	Үндсэн брэндбүүк бий болгох		4,000,000
3	Шторк танилцуулга /Хятад, Англи хэлээр/	4	4,000,000
	НИЙТ		9,000,000